

**ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД  
ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ХИЙСЭН  
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2018.01.02

Арвайхээр хот

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2008 оны 44 дүгээр захирамжаар батлагдсан “Иргэдээс аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс албадад гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журам”-ыг мөрдлөг болгон иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх зарчим баримтлан ажиллаа.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэхтэй холбоотой сургалтыг Төгрөг, Гучин-Ус, Богд, Хайрхандулаан, Баруунбаян-Улаан сумдын албан хаагчдад хийж, арга зүйгээр ханган, нийт 125 албан хаагч хамрагдлаа. Мөн төв болон хангайн бүсийн 6 сумын ЗДТГ-ын дарга нартай видео хурлыг хийж, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, тайлан мэдээг үр дүнтэй гаргах талаар мэдээлэл өгч ажиллалаа.

Халамжийн гэр бэлтгэн нийлүүлэх, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, орон нутгийн төсвийн халамж, үйлчилгээний зардлаас амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой орон гэргүй 100 иргэнд 200 сая төгрөгийн үнэ бүхий 100 ширхэг гэр олгож амьдрал ахуйг нь дээшлүүллээ.

Аймгийн Засаг даргад хандаж тайлант онд мөнгөн тусламж хүсэж өргөдөл ирүүлсэн 76 иргэнд 8.8 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлсэн.

“Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д 2017 онд нийт 99 иргэн хандснаас санал, хүсэлт 61 буюу 61.6, гомдол 35 буюу 35.3, талархал 3 буюу 3.1 хувийг тус тус эзэлж байна. Төрийн байгууллага, албан тушаалтнуудад иргэдээс ирүүлсэн нийт 99 гомдол, саналын 90 буюу 90.9 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 9 буюу 9.1 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна.

Мөн иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 70321111 дугаарын утсаар болон биечлэн авч шийдвэрлэж байна. Тайлангийн хугацаанд нийт 2237 өргөдөл, гомдол, санал ирснээс 2108 буюу 94.2 хувь нь хуулинд заасан хугацаанд

шийдвэрлэгдэж, 129 буюу 5.7 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Ирсэн өргөдөл, гомдол, саналын 1241 мэдээлэл, тодруулга, 983 гомдол, 13 санал, байна. Тус төвд ирүүлсэн нийт 983 гомдлоос 323 буюу 32.8 хувь нь Арвайхээр сумын ЗДТГ-ын Төрийн үйлчилгээний нэгдсэн төв, 225 буюу 22.8 хувь нь хот тохижилт, үйлчилгээтэй, 66 буюу 6.7 хувь нь боловсролын салбарын ажил, үйлчилгээтэй холбоотой иргэдээс хандсан гомдлууд зонхилж байна.

Долоо хоног бүрийн Мягмар гаригт хуралддаг аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлаг, албадын дарга нарын “Шуурхай хуралдаан”-ыг 38 удаа зохион байгуулж, байгууллагын удирдлагуудад хугацаатай үүрэг даалгавар өгч, 15 сонсгол хийж, 7032-1111 утсанд иргэдийн ирүүлсэн санал, гомдлыг шийдвэрлэх талаар 38 удаагийн мэдээллийг сонсч, шийдвэрлэлт, хариу өгсөн байдалд дүгнэлт хийж, төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэхэд байгууллагын уялдаа холбоог сайжруулж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллав.

2017 оны жилийн эцсийн байдлаар аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 15521 өргөдөл, гомдол, санал ирсэний 332 буюу 2.2 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 15147 буюу 97.5 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдлээ.

Ирсэн өргөдөл, гомдлыг агуулгын хувьд авч үзэхэд, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, газар өмчлөх, эзэмших хүсэлт, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах, байгууллагын үйлчилгээ үйл ажиллагаатай холбоотой 9524 буюу 61.4 хувь, тэтгэвэр тогтоолгох 1873 буюу 12.1 хувь, материал, мөнгөн тусламж хүссэн 1643 буюу 10.6 хувь, хөдөлмөр эрхлэлт 1260 буюу 8.1 хувь, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 1094 буюу 7.0 хувийг тус тус эзэлж байна.

Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг 2017 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж, хавсралтаар хүргүүллээ.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИРГЭДЭЭС НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН  
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2018.01.02

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт /Хувь/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн		
1	Аймгийн ЗДТГазар	412	390	257	-	22	94.6
2	Агентлагууд	1082	1042	37	-	40	96.3
3	Сумд	11790	11649	1536	-	141	98.8
4	Аймгийн Мэдээлэл, шуурхай удирдлагын төв /703211111/	2237	2108	2237	-	129	94.2
Дүн		15521	15189	4067	-	332	97.8

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИРГЭДЭЭС НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН  
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ /ХЭЛБЭРЭЭР/

2018.01.02

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол	Үүнээс:			
			бичгээр	Утсаар	Биечлэн	Бусад
1	Аймгийн ЗДТГазар	412	412	-	-	-
2	Агентлагууд	1082	1048	-	34	-
3	Сумд	11790	10726	-	1064	-
4	Аймгийн Мэдээлэл, шуурхай удирдлагын төв /70321111/	2237	-	2237	-	-
Дүн		15521	12186	2237	1098	-

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

## ӨРГӨДӨЛ, ГОМДОЛД ЗОНХИЛЖ БУЙ АСУУДАЛ

2018.01.02

Арвайхээр

Аймгийн нэр	/тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/			
Өвөрхангай аймаг	Нийт өргөдөл, гомдол, санал 15521 ирсэн байна.	хүсэлт	12358	79.6%
		гомдол	1625	10.4%
		санал	1538	10.0%
	Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, газар өмчлөх, эзэмших хүсэлт, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах, нийгмийн даатгалт, байгууллагын үйлчилгээ үйл ажиллагаатай холбоотой асуудлууд	9524	61.4%	
	Тэтгэвэр тогтоолгох	1873	12.1%	
	Материал, мөнгөн тусламж хүссэн	1643	10.6%	
	Хөдөлмөр эрхлэлт	1260	8.1%	
	Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой	1094	7.0%	
	Гэр, орон сууц хүссэн	90	0.6%	
	Сургууль, курст суралцах	37	0.2%	
<ul style="list-style-type: none"> <li>• Аймгийн Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 70321111 утсанд 2237 иргэн хандаж, цаг үеийн шинжтэй мэдээллийг 1241 иргэнд өгсөн байна.</li> <li>• Хархорирн сумын ЗДТГазар, Арвайхээр сумын Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, газар өмчлөх, эзэмших хүсэлт, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах, нийгмийн даатгалтай холбоотой нийт 4076 өргөдөл, гомдол ирүүлсэний 4966-г нь хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Энэ нь бусад сумдтай харьцуулахад харьцангуй өндөр байгаа шалтгаан нь хүн ам олон байгаатай холбоотой байна.</li> </ul>				

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР